



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 89

Пионер толгой

Тарваган тахлаас сэргийлэх ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Дархлаажуулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалт, Засгийн газрын 2001 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 67 тоот тогтоол, Тарваган тахал өвчинөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэх тухай Эрүүл мэндийн сайдын 165 тоот тушаал, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирлын 2013 оны 07 сарын 05-ны өдрийн А/26 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тарваган тахлаас сэргийлэх дархлаажуулалтыг 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 25-ны өдрийг хүртэл зохион байгуулсугай.

2. Тарваган тахлаас сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Сүхбаатар (Эрүүл мэндийн төвийн дарга)

Гишүүд: Б.Ганцэцэг (Вакцинатор)

Г.Мөнхбаатар (Цэнгэл 1 дүгээр багийн эмч)

О.Долгормаа (Давааны ам 2 дугаар багийн эмч)

Ж.Мөнхдалай (Буга 3 дугаар багийн эмч)

Ч.Болорсайхан (Хөвийн ам 4 дүгээр багийн эмч)

3. Дархлаажуулалтын ажилд шаардагдах бензин шатахууны зардал 200,000 (Хоёр зуун мянга) төгрөгийг байгууллагын зохих төсвөөс гарган зарцуулахыг Эрүүл мэндийн төвийн дарга (Г.Сүхбаатар), нягтлан бодогч (Б.Өлзиймаа) нарт зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Сүглэгмаа)-д даалгасугай.



ДАРГА

Б.ГАНТУЛГА

643101281